



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2020 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 51

Мөрөн

□ “Хөвсгөл Эрчим Хүч” ХХК-ийн Төлөөлөн  
удирдах зөвлөлийн гишүүдийг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, 77 дугаар хуулийн 77.4, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 75 дугаар зүйлийн 75.4, 79 дүгээр зүйлийн 79.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 61 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл Эрчим Хүч” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийг төлөөлж оролцох гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

1. Ц.Хуншагай-аймгийн Татварын хэлтсийн дарга
2. Т.Энхтуяа- аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
3. Р.Машбат-аймгийн ИТХ-ын Ажлын албаны ажилтан
4. Ж.Баяндалай-аймгийн Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн дарга
5. С.Долгоржав-аймгийн ИТХ-ын Ажлын албаны ажилтан
6. Г.Энхбаяр-аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

2. “Хөвсгөл Эрчим Хүч” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд дараах хүмүүсийг томилсугай.

1. А.Дандар- Мөрөн сумын иргэн
2. Ж.Ганболд-Мөрөн сумын иргэн
3. Д.Цогт-Эрдэнэ- Мөрөн сумын иргэн

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2018 оны 05 дугаар сард багтаан хуралдуулж, удирдамжийг батлуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Болд)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 74 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

110150172

5. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Гончиг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР